



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.03.15 № А-3/1263
танай _____-ны № _____-т

Тендер шалгаруулалтын тухай

Тус газраас 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр ЗТХЯ/20240101116 дугаартай зарласан “Зам, тээврийн хөгжлийн сайдын багцад тусгагдсан төсөл, арга хэмжээний авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээ” авах төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын баримт бичигт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт “Захиалагч ажлын хувьд 30 тэрбум, барааны хувьд нэг тэрбум, үйлчилгээний хувьд 300 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад гадаадын этгээд оролцохыг хориглож үл болно...”, 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэгт “Нээлттэй тендер шалгаруулалтын тендер хүлээн авах эцсийн хугацаа ажлын 15-аас дээш, энэ хуулийн 8.3-т заасан тендер шалгаруулалтад ажлын 20-иос дээш өдөр байхаар заана...” гэж заасны дагуу дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

1. ТШЗ 12.1-д Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг баталгаажуулан, баталгаат орчуулгын хамт ирүүлнэ гэж
2. ТШЗ 26.1-д Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр, Цаг: 12 цаг 00 минут гэж;
3. ТШЗ 26.2-д Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр, Цаг: 12 цаг 10 минут гэж;

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ЛХАМСҮРЭН

1324023417

ТХААГ-2024-А4